

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХОРИХ БАЙГУУЛЛАГА ДАХЬ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЖИЛЛАГААНЫ ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

POSITION OF PROVIDING SECURITY IN THE PRISONS AMONG NATIONAL SECURITY



Ц.ОЧГЭРЭЛ

ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч, докторант, хурандаа
OCHGEREL TS.

Dean of Court Decision Execution Studies center, Research and Development Institute, colonel

Товч агуулга: Хорих байгууллагын аюулгүй байдал, түүний бүрэлдхүүн хэсэг, тогтолцооны зүй тогтол нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын ойлголт, үзэл баримтлалтай хэрхэн уялдаж байгаад дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Abstract: This scientific-researching report is aimed to analyze how security of the prisons, its structural parts and natural law has been associating with the understanding and concept of the national security of Mongolia.

Түлхүүр үгс: Аюулгүй байдал, нөлөөлөх хүчин зүйл, хорих байгууллага, хоригдогсод, үр дагавар.

Key words: Security, affecting factors, agency of executing court decision, prisoners, consequence.

Аюулгүй байдал судлалын чиглэлээрх бүтээлүүдэд үндэсний аюулгүй байдлыг хангахад хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагааны гүйцэтгэх үүрэг, бүтэц, харилцан хамаарлын асуудлыг тухайлан тусгаж судалсан судалгааны ажил өнөөдрийг болтол хомс байна гэж үзэж болохоор байна.

Хуульд заасан үндэслэлээр тодорхой төрлийн гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж цагдан хоригдсон, баривчлагдсан, хорих ял шийтгүүлсэн хоригдогч, ялтныг нийгмээс тусгаарлах чиг үүргийг хэрэгжүүлж буй хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах асуудлыг агуулга, мөн чанарын хувьд үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо, үзэл баримтлалтай хэрхэн уялдаж байгаа талаар судлан үзэх нь зайлшгүй юм. Ингээд үндэсний аюулгүй байдлын талаарх ойлголтыг товч авч үзье.

Үндэсний аюулгүй байдлын ойлголтын талаар.

Аливаа улс гүрний хувьд аюулгүй байдлаа хангах асуудал нь иргэн, ард түмний болон төрийн хэвийн оршин тогтнох, хөгжин дэвших хэрэгцээнд суурилсан байдаг. Хүн төрөлхтөн түүхэн цаг хугацааны явцад өнөөдрийн нийгмийн амьдралын хэв маягыг олох хүртэл бүхий л үе шатанд төрөл бүрийн аюул, эрсдэлтэй нүүр тулгарч, түүнээс хамгаалах, хор уршиг багатай даван гарах замаар хөгжлийн дараагийн түвшинд тэмүүлж ирсэн. Байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдэлтэй сөрөг үр дагавар бүхий шинэ төрлийн аюул, занал цаашид ч бие хүний болон нийгмийн бүхий л түвшиний байгууллагууд, тэр дундаа төр, улсын аюулгүй байдалд

заналхийлсээр байх төлөвтэй байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын талаарх суурь томъёоллыг Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ”¹ хэмээн тодорхойлсон байдаг. Хуулийн энэ томъёоллоос авч үзвэл үндэсний аюулгүй байдлыг хангах явдлын үндсэн судлагдахуун, хамгаалагдах объект нь үндэсний язгуур ашиг сонирхол байх ойлголт урган гарч байна. Харин тус хуулинд “Үндэсний язгуур ашиг сонирхол”-д Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, үндэсний эв нэгдэл, хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдсан байдал, эдийн засгийн тогтвортой, экологийн тэнцвэрт хөгжил багтана,² гэж хуульчилжээ.

Тусгаар тогтносон, бие даасан улс орны хувьд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах асуудал нь нэг талаас улс орныг удирдан чиглүүлж буй төрийн болон иргэний амин чухал ашиг сонирхол, улс, үндэстний хэмжээний үнэт зүйлс аюул заналаас хамгаалагдан сэргийлэгдсэн байдал, нөгөө талаас батлан хамгаалах, эдийн засаг, улс төрийн түвшинд гадаад, дотоод аюулыг арилгах, таслан зогсоох чадвар, нөөц бүрдсэн байх явдал юм. Чухамхүү үндэсний язгуур ашиг сонирхол хэмээх томъёололд дээрх ойлголтуудыг хамруулан судлах явдал нь үндэсний аюулгүй байдлын мөн чанарыг илэрхийлэх нэг хүчин зүйл юм.

“Үндэсний аюулгүй байдал гэдэг нь нийгмийн бүх организм, олон нийтийн бүтцүүд саад, бэрхшээлгүй хөгжил, дэвшилд хүрэх баталгаа бий болж, хувь хүн, нийгэм, төр улсын оршин тогтнох, хөгжиж дэших ирээдүйтэй нөхцөл бүрдсэн байдал”³ гэж манай улсын зарим судлаачид томъёолсон байна. Харин ОХУ-ын 2020 он хүртэлх үндэсний аюулгүй байдлын стратеги хөтөлбөрт “үндэсний аюулгүй байдал гэдэг нь төрийн аюулгүй байдал, батлан хамгаалалт, ОХУ-ын тогтвортой хөгжил, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, иргэдийн амьдралын түвшин, үндсэн хуулийн эрх, эрх чөлөөг хангагдаж, дотоод, гадаадын заналхийллээс хувь хүн, нийгэм, төр улс хамгаалагдсан байдал”⁴ хэмээн авч үзсэн. Түүнчлэн, дэлхийн бусад улс орнууд ч тус тусын улс орны газар зүйн байршил, улс төр, эдийн засгийн тогтолцоо, чадавх, цэрэг, батлан хамгаалах хүчин чадал, бүс нутаг, үндэстний онцлог зэргээс хамааран үндэсний аюулгүй байдал, түүнийг хангах үйл ажиллагаа, тогтолцооны чиглэлээ томъёолсон байдаг.

Үндэсний аюулгүй байдалын талаарх ойлголт, судлаачдын дүгнэлтээс үзвэл улс үндэстний язгуур ашиг сонирхол, амьдралын суурь хэрэгцээ зэрэг аюулгүй байдлыг хангах зорилгыг нөхцөлдүүлж буй зүйлс нь цар хүрээ, шинж чанарын хувьд хувь хүний, нийгмийн, төрийн түвшиний гэж ангилагдаж байна. Өөрөөр хэлбэл, энэхүү гурван түвшиний амин чухал ашиг сонирхол, амьдрах, хөгжих, оршин тогтнох хэрэгцээний нэгдэл нь үндэсний аюулгүй байдлын хангах ажиллагааны зорилго, агуулгыг бий болгож буй үндсэн нөхцөл юм.

Хорих байгууллага (хууль сахиулах)-ын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа үндэсний аюулгүй байдлын бүрэлдхүүн хэсэг болох нь

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 1 дүгээр зүйлийн

¹ <http://legalinfo.mn/law/details/18?lawid=18>

² Мөн цахим хуудсанд.

³ Ч.Улаанхүү. Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудал. УБ., 2014. 76 дахь тал

⁴ С Т Р А Т Е Г И Я национальной безопасности Российской Федерации до 2020 года <http://www.scrf.gov.ru/news/436.html>

1.1.5-д "Монгол Улсын төр, нийгэм, иргэний аюулгүй байдал харилцан, уялдаатай хангагдсанаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдал баталгаажина", 3 дугаар зүйлийн 3.3-т "...хүний эрх эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, ...нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн"⁵ гэж заасан бөгөөд судлаачийн зүгээс төрийн буюу улсын аюулгүй байдлыг хангах тогтолцоо, шаардлагыг гүнзгийрүүлэн судлах зорилт дэвшүүлээгүй хэдий ч иргэн, нийгмийн аюулгүй байдлыг хангах явдал нь төрийн хүлээх үндсэн үүрэг төдийгүй улс орны аюулгүй байдлын анхдагч суурь нөхцөл, эцсийн үр дүнгийн гол илэрхийлэл юм гэдгийг тэмдэглэж байна.

Хувь хүний, нийгмийн аюулгүй байдлыг хангах нь үндэсний язгуур ашиг сонирхлын цөм хэсэг гэж үзвэл түүнийг ямар арга замаар хангах вэ? гэсэн асуулт гарч ирж байна. Аюулгүй байдлыг хангах тогтолцоо, арга зам нь хамгаалагдах гэж буй объектын онцлогоос шалтгаалан төлөвлөлт, нөхцөл байдлыг судлан шинжлэх, аюул, заналыг үнэлэх, хүч хэрэгсэлээ тооцоолон хуваарилах, бүрдүүлэгч бүтцүүдийн уялдаа холбоог хангах зэрэг өргөн цар хүрээ бүхий арга хэмжээний цогц бүрдэл юм.

Манай улсын хувьд улс төр, нийгмийн шинэ тогтолцоонд шилжсэн сүүлийн хорь гаруй жилд хүний, нийгмийн аюулгүй байдлыг хангах талаар шууд болон шууд бус байдлаар Үндсэн хууль, бусад хууль, УИХ, Засгийн газраас батлан гаргасан шийдвэрүүд, үзэл баримтлал, хөтөлбөрүүдэд тусган эрх зүйн, төрийн байгууллын тогтолцоог бий болгох замаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын зэрэг бүхий л салбарыг хөгжүүлэх суурь алхмуудыг хийж иржээ.

Дээр дурдсан иргэн, нийгмийн хөгжлийг дэмжсэн бодлого нь үндэсний аюулгүй байдлыг бүрдүүлэгч хүчин зүйл мөн хэдий ч хүний болон нийгмийн тогтвортой хөгжил, аюулгүй байдалд бодитойгоор заналхийлж, үлэмж хэмжээний хор уршгийг дагуулж буй гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудал хурцаар тавигдаж байна. Гэмт явдлын бүтэц, тодорхой төрлийн гэмт хэргийн шинж хурдацтай хувьсан өөрчлөгдөж байгаагийн зэрэгцээ нийт гэмт хэргийн дотор үндэстэн дамнасан, зохион байгуулалттай, улс төр, эдийн засаг, төрийн өндөр албан тушаалын хүрээг хамарсан авилга, эдийн засаг, хүн худалдаалах, хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргийн тоон үзүүлэлт өссөөр байна.

Энэхүү онцлог, ноцтой үр дагавар бүхий гэмт явдлын шууд болон шууд бусаар улс орны бүтээн байгуулалт, эдийн засаг, улс төрийн чадавх, иргэдийн амьдралын түвшин, нийгмийн байгуулалын хөгжил дэвшилд учруулж буй хор аюулын хэр хэмжээг тооцоолох боломжгүй юм. Дээр дурдсан болон бусад гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, нотлох, гэм бурууд тохирсон ял шийтгэл оногдуулах, нийгмээс тусгаарлан хорих, ял эдлүүлэх асуудал нь нэг талаас шүүх болон хууль сахиулах салбарын үйл ажиллагаа, нөгөө талаас иргэн, нийгмийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны нэг хэсэг болох нь зүйн хэрэг юм.

Улсын хэмжээнд үйлдэгдэж буй бүхий л төрлийн гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагч эсвэл гэмт буруутай нь шүүхээс тогтоогдон хорих, баривчлах ял шийтгүүлсэн этгээдийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай болон Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн

⁵ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоол. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УИХ-ын Тамгын газрын хэвлэх цех., 2010. 3 дахь тал

хүрээнд нийгмээс тусгаарлах чиг үүргийг хэрэгжүүлдэг хорих анги, баривчлах байр, цагдан хорих байр (цаашид хорих байгууллага гэх)-ны хэвийн үйл ажиллагааг хангах явдал нь аюулгүй байдал судлалын үүднээс бие даасан чиглэл байхын зэрэгцээ үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоон дахь дотоод аюулгүй байдалд тодорхой нөлөө үзүүлэхүйц үүрэг бүхий бүрэлдхүүн хэсэг гэж үзэж байна.

Аюулгүй байдлын онолын үүднээс хувь хүн, тодорхой хүмүүсийн бүлэг, эвсэл, гэр бүл, нийгмийн байгуулал, төр улс гэх мэт бүхий л түвшинд сөрөг нөлөөлөл бүхий аюул, заналхийллээс хамгаалах, хэвийн оршин тогтнох, хөгжин дэвших бодит хэрэгцээний үндсэн дээр аюулыг үнэлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, аюулыг эрсдэл багатайгаар даван гарах зорилтыг агуулсан цогц арга хэмжээг хэрэгжүүлдэг. Үүний нэгэн адил хорих байгууллагын үйл ажиллагааны явцад тодорхой хүн, бусад объектын аюулгүй байдлыг хангах замаар хоригдогч, ялтныг нийгмээс тусгаарлах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Хорих байгууллагын аюулгүй байдлын тухай

Хорих байгууллагын үйл ажиллагааг аюулгүй байдал судлалын үүднээс судлахдаа юуны өмнө аюулд өртөж болзошгүй объектыг томъёолох шаардлагатай. Гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж буй хоригдогч, хорих болон баривчлах ял шийтгүүлсэн ялтны зүгээс түүнчлэн, хорих байгууллагын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй улс төр, эдийн засаг, бизнесийн болон гэмт бүлэглэлүүдийн идэвхтэй үйл ажиллагаа, бусад хүчин зүйлээс үүдэлтэй аюул заналхийлэл бодитой байсаар байна. Иймд хорих байгууллагын аюулгүй байдлын объектыг дараах байдлаар ангилж болно:

1. Хорих анги, цагдан хорих, баривчлах байр

Энэ нь ШШГБ-ын хуулиар хүлээсэн үүрэг, чиглэлтэй салшгүй холбоотой. Өөрөөр хэлбэл, ШШГБ-ын үйл ажиллагааны үндсэн чиглэлийн нэг нь хорих анги, баривчлах цагдан хорих байрны хэвийн ажиллагааг хангах явдал. Хэвийн үйл ажиллагааг хангагдсан байдал гэдэгт юуны түрүүнд хоригдогч, ялтны зүгээс үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, ноцтой гэмт зорилго бүхий нуугдмал санаа, төлөвлөлтийг илрүүлэх арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн байхыг ойлгоно.

Үүний зэрэгцээ хорих анги, баривчлах цагдан хорих байрны барилга байгууламж, хамгаалалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн байнгын найдвартай ажиллагаа; санхүүгийн болон бусад материаллаг хангамж тасралтгүй хангагдсан байдал зэрэг нь хорих ангийн хэвийн үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсгүүд юм.

2. Ажилтан, албан хаагчид

Хорих ял эдэлж байгаа болон цагдан хоригдож буй хоригдогсод нь ямар нэг гэмт санаа бодлоо амжилттай хэрэгжүүлэх эсвэл нуун далдлах, өөрийн хань хамсаатантай холбоо тогтоох гэх мэт сөрөг үйлдлийнхээ явцад ажилтан, албан хаагчийн аюулгүй байдалд шууд болон шууд бусаар халдаж болзошгүй байдаг. Тухайлбал: эрхшээлдээ оруулахыг эрмэлзэх, айлган сүрдүүлэх, дарамтлах мөн амь нас, эрүүд мэндэд халдах гэх мэт.

3. Хоригдогч, ялтны болон бусад хүмүүс

Хоригдогч, ялтны зүгээс хамт хоригдогсдын амь нас, эрүүл мэндэд халдах, дарамтлах зэрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсээр байгаа нь судалгаанаас харагдаж байна. Түүнчлэн, эрүүгийн хариуцлагаас зайлсхийх зорилгоор эсвэл сэтгэл зүйн онцлог, бусад шалтгааны улмаас амиа хорлох, бие эрхтэндээ гэмтэл учруулах зэрэг

ноцтой үйлдлээс урьдчилан сэргийлэх, тасалан зогсоохын тулд хоригдогч, ялтны аюулгүй байдлыг хангах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэх шаардлагатай.

Энд бусад хүмүүс гэдэгт хоригдогч ялтны зүгээс үйлдэж болзошгүй гэмт халдлагад өртөж болзошгүй иргэд, нийгмийн бусад төлөөлөл, хорих ангийн бүс, байрлалд түр хугацаагаар нэвтэрч байгаа болон тодорхой ажил үүрэг гүйцэтгэж байгаа албан тушаалтан, иргэдийг хамруулж ойлгох нь зүйтэй.

Хорих байгууллагын аюулгүй байдал гэдгийг хорих байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй, амжилттай хэрэгжих явц, зорилтод сөрөг нөлөөлөл үзүүлэх, улмаар алдагдуулж, ноцтой хор уршиг учруулж болзошгүй аюул, занал, эрсдэлт нөхцөл байдлыг урьдчилан судлах, үнэлэх, хор аюулыг бууруулах, таслан зогсоох, арилгах, урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ, үр дүнгийн нэгдлийг агуулсан нөхцөл гэж тодорхойлж байна.

Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагааны хүрээнд дээр дурдагдсан объектыг аливаа гэмт халдлага, болзошгүй эрсдэлээс хамгаалах, учирч болох аюул, заналыг үнэлэх, түүнийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, хор уршгийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь дан ганц хорих анги, баривчлах, цаглан хорих байранд хэрэгжихээс гадна тодорхой тохиолдолд онцгой байдал, цагдаа, тагнуул, тахарын алба, бусад хуул сахиулах байгууллагатай нягт хамтран ажиллах шаардлага үүснэ.

Тухайлбал, хорих анги, баривчлах цагдан хорих байранд нүүрлэж болзошгүй байгалын болон галын аюулаас урьдчилан сэргийлэх, даван гарахад онцгой байдлын, хорих байгууллагад үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн, хорих байгууллагаас хоригдогч, ялтан оргох, хил, хилийн бүс рүү нэвтрэх оролдлогыг таслан зогсоох чиглэлээр хилийн, эрэн сурвалжлах чиглэлээр тахарын албатай гэх мэт хамтын ажиллагааг үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран ажиллана.

Дүгнэлт

Хорих байгууллагын аюулгүй байдал хангагдсанаар үндэсний аюулгүй байдлын бүрэлдхүүн хэсэг болох дотоод аюулгүй байдал, нийгмийн дэг журам, тогтвортой байдал, иргэн, нийгмийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон дараах үр дагавар бий болно:

1. Хоригдогч ялтан шүүгчийн захирамж, шүүхийн шийтгэх тогтоолоор тодорхой хугацаагаар нийгмээс тусгаарлагдсанаар иргэн, байгууллагад учруулж болох хор уршгаас бодитой сэргийлнэ.

2. Хорих байгууллагын барилга, байгууламжийг шаардлага хангасан стандартын түвшинд байгуулан, аюулгүй байдлын цогц арга хэмжээг хэрэгжүүлсэнээр хоригдогч, ялтны зүгээс дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлнэ.

3. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах арга хэмжээний нэг болох нөлөөллийн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэнээр ялтныг нийгэмшүүлэх нөхцөл бүрдэж, суллагдсаны дараах нийгэмд аюултай шинж багасч рецидив гэмт хэрэг буурахад нөлөөлнө.

4. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн эрхийг нөхөн сэргээх боломж бүрдэнэ.

5. Нийгэмд шударга ёсыг сэргээх, хууль дээдлэх үзэл төлөвших, иргэд айдас,

түгшүүргүй амьдрах итгэл бий болоход нөлөөлнө.

6. Хорих байгууллагын аюулгүй байдал хангагдсанаар хорих байгууллагад ажиллаж буй албан хаагч, хоригдогч ялтан болон тэдгээрийн ар гэр, бусад хүмүүсийн аюулгүй байдал хангагдана.

7. Нийгэм, эдийн засгийн бусад эерэг үр дагавар бий болно.

Дээрх бүгдээс үзвэл төрийн онцлог чиг үүргүүдийн нэг болох хоригдогч ялтныг нийгмээс тусгаарлах арга хэмжээг хэрэгжүүлж буй хорих байгууллагын аюулгүй байдал хангагдсанаар үндэсний аюулгүй байдал дахь дотоод аюулгүй байдлыг илэрхийлэгч язгуур ашиг сонирхлын гол бүрэлдхүүн хэсэг болох иргэний болон нийгмийн аюулгүй байдлыг хангахад чухал нөлөө үзүүлэх нь харагдаж байна.

Тиймээс хорих байгууллагын аюулгүй байдлын агуулга, мөн чанарыг судлан шинжлэх асуудал нь аюулгүй байдал судлалын нэг салаа мөчир болохын зэрэгцээ хорих байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй, амжилттай хэрэгжих явц, зорилтод сөрөг нөлөөлөл үзүүлэх, улмаар алдагдуулж, ноцтой хор уршиг учруулж болзошгүй аюул, занал, эрсдэлт нөхцөл байдлыг урьдчилан судлах, үнэлэх, хор аюулыг бууруулах, таслан зогсоох, арилгах, урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээ, үр дүнгийн нэгдэл нь үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоон дах дотоод аюулгүй байдлыг хангах ажиллагааны салшгүй нэг хэсэг хэмээн дүгнэж байна.

Эх сурвалжийн жагсаалт:

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он.
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2002 он.
3. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль 1999 он.
4. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль 2001 он.
5. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010 он.
6. Ч.Улаанхүү. Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудал. УБ., 2014 он.
7. Ж.Бор. В.Чулуунбат. Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс. УБ., 2012 он.
8. <http://legalinfo.mn/law/details/18?lawid=18>
9. <http://www.scrf.gov.ru/news/436.html> Стратегия национальной безопасности Российской Федерации до 2020 года.